



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 11 сарын 12 өдөр

Дугаар 8/56/2

Улаанбаатар хот

Г
Эрүүл мэндийн байгууллагуудыг бүх нийтийн
бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.4, Засгийн газрын 2020 оны 178 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2020 оны 33 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн коронавируст халдварт (Ковид-19)-ын цар тахалтай тэмцэх, хариу арга хэмжээг эрчимжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн байгууллагуудыг 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 06:00 цагаас 11 дүгээр сарын 17-ны өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2. Эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгох нь:

2.1. Коронавируст халдварт (Ковид-19) тухайн орон нутгийн хүн амын дунд тархах эрсдэлийг үнэлэн, халдвараас сэргийлэх, цар тахлын үед эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах төлөвлөгөөг тодотгох, мөрдөгдөж байгаа тушаал, албан даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэх;

2.2. Харилцаа холбоо, зарлан мэдээлэх хэрэгслийн бэлэн байдлыг хангах, тогтоосон дохиогоор ажиллах арга, ажиллагаанд эрүүл мэндийн ажилтан бүрийг сургаж дадлагажуулах;

2.3. Хүний нөөц, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж, оношлуур, ариутгал, халдвартгүйтгэлийн бодис, хувийн хамгаалах хувцас хэрэгсэл болон бусад хэрэгцээг тооцоолон, нөөцийг бүрдүүлэх;

2.4. Салбар дундын төлөвлөгөө, мэдээ, мэдээлэл солилцон, төрийн болон төрийн бус байгууллага, олон нийт, иргэдтэй хамтран ажиллах;

2.5. Хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоох, хүч хэрэгсэл, гамшгийн болон орон нутгийн нөөцийг дайчлахад хамтран ажиллах;

2.6. Нийтийг хамарсан үзлэг, сургалт, сурталчилгаа зохион байгуулахыг цуцлах, хориглох;

2.7. Харилцаа холбоо, цахилгаан, дулаан, хүнс хангамж, шатахуун, түлшний нөөцийг бүрдүүлэх;

2.8. Голомтын бүсээс хүн амыг түр нүүлгэн шилжүүлсэн тохиолдолд иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх;

2.9. Байгууллагын хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах шаардлагатай арга хэмжээг авах;

2.10. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээн дэх иргэдийг төөрөгдүүлсэн худал мэдээллийн тархалтыг бууруулах, зогсоох арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэн, иргэдэд үнэн зөв мэдээлэл түгээх;

2.11. Зайлшгүй шаардлагатай тохиолдолд иргэн, байгууллага, хуулийн этгээдээс холбогдох мэдээллийг авч, мэдээллийн нууцлалыг хадгалах, авсан мэдээллээ урвуулан ашиглахгүй байх;

2.12. Хуульд заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлэх.

3. Тушаалын хэрэгжилтэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Я.Амаржаргал/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн дэд сайд /Ш.Анхмаа/-д даалгасугай.

5. Энэхүү тушаал батлагдан гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/93 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



ГАМШГААС ХАМГААЛАХ ЭРҮҮЛ МЭНДИЙН
УЛСЫН АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
САЙД  T. МӨНХСАЙХАН